



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/09

Арвайхээр

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
бүтцэд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.4 дэх хэсэг, Засгийн газрын “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” 2016 оны 9 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2019 оны “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/601 дүгээр захирамжийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн “Газар, байгаль орчин, аялал жуулчлалын салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн” гэснийг “Газар, байгаль орчин, аялал жуулчлалын салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн”, “Дэд бүтцийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн” гэснийг “Дэд бүтцийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн” гэж тус тус өөрчилсүгэй.

2.Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцэд оруулсан өөрчлөлтийг 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100022